



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2006 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 447

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын "Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль"-ийн 22 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн **ТУШААХ нь:**

1. "Гадаадын зээл, тусламжийн бүртгэл, мэдээллийн сан байгуулах, ашиглах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын газар /О.Эрдэмбилэг/-т даалгасугай.



Н.БАЯРТСАЙХАН



Сангийн сайдын 2006 оны 12
дугаар сарын 27-ний өдрийн 447
дугаар тушаалын хавсралт

ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН БҮРТГЭЛ, НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САН БАЙГУУЛАХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын зээл, тусламжийн холбогдолтой мэдээ, тайланг бүртгэх, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг дагаж мөрдөнө.

1.2. Гадаадын зээл, тусламжийн нэгдсэн мэдээллийн санг /цаашид "Нэгдсэн мэдээллийн сан" гэх/ Зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулна.

1.3. Монгол Улсын байгууллага, иргэдийн чадавхийг дээшлүүлэх болон дэмжлэг туслалцаа үзүүлэх бусад бүх хэлбэрээр Монгол Улсад Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн /цаашид "Төсөл, хөтөлбөр" гэх/ хэрэгжилтийг хариуцаж байгаа байгууллага /цаашид "Хэрэгжүүлэгч байгууллага" гэх/ тухайн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг энэ журмын дагуу нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлж, тайлагнана.

1.4. Хэрэгжүүлэгч байгууллагууд төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд гаргаж өгөхдөө ил тод, нээлттэй байх зарчмыг баримтална.

Хоёр. Зээл, тусламжийн төслийн нэгдсэн

мэдээллийн санг бүрдүүлэх тухай

2.1. Зээл, тусламжийн төслийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх

2.1.1. Гадаадын түнш байгууллага/орон/-ын дэмжлэг авч гадаад орны Засгийн газар, олон улсын байгууллагын гэрээ хэлэлцээр болон Засгийн газрын байгууллага хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу баталгаажсан төсөл, хөтөлбөр (санхүүгийн, төсөл/техник туслалцаа, бараа, бүтээгдэхүүний хэлбэртэй г.м.)-ийг Зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн мэдээллийн санд Хүснэгт 1-ээр батлагдсан маягаар бүртгэн авч бүртгэлийн дугаар өгнө. Бүртгэлийн дугаарыг төсөл хэрэгжиж буй салбар, хэрэгжүүлэгч байгууллагын нэрийг харгалзан олгоно. Төсөл, хөтөлбөрийн бүртгэлийн дугаарыг тухайн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, төлбөр хураамжаас чөлөөлөх, гадаадын зөвлөхөд виз олгох, болон төслийн хөрөнгийг бүртгэх, автомашины дугаар авах болон төсөл, хөтөлбөрийн бусад үйл ажиллагаанд ашиглана.

2.1.2. Хэрэгжүүлэгч байгууллага нь төсөл, хөтөлбөрийг гэрээ, хэлэлцээр байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлнэ. Төсөл хөтөлбөрийг нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэхдээ зээл, тусламжийн гэрээ, хэлэлцээрийн хуулбар, Засгийн газар болон холбогдох байгууллагын зээл, тусламж

авах тухай шийдвэр, төслийн баримт бичгийг, түүний албан ёсны орчуулгын хамт ирүүлнэ.

2.1.3. Төслийн баримт бичигт дараах зүйлсийг багтаасан байна. Үүнд:

- 2.1.3.1. Төсөл, хөтөлбөрийн зорилго /Монгол Улсын Үндэсний хөгжлийн стратеги болон бусад бичиг баримттай уялдаж буй эсэх/,
- 2.1.3.2. Үйл ажиллагааны хамрах хүрээ /засаг захиргааны нэгжээр/, салбар,
- 2.1.3.3. Хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллага, оролцогч талууд,
- 2.1.3.4. Хэрэгжих хугацаа,
- 2.1.3.5. Төсөв, жил бүрийн төсөл, хөтөлбөрийн төсөв, гадаад дотоод эх үүсвэрийн хуваарилалт, техник эдийн засгийн үндэслэл /зардлыг тооцож болох үндсэн үзүүлэлтээр тооцох, төслөөс хүлээгдэж буй үр дүнг оруулах/. Төсөл, хөтөлбөрийн зардал нь цалин, ашиглалтын зардал, томилолтын зардал, гадаад, дотоодын зөвлөх үйлчилгээ, сургалтын зардал, тоног төхөөрөмжийн зардал болон бусад зардлын ангиллаар тодорхой төсөвлөгдсөн байна.
- 2.1.3.6. Төслийн хүрээнд гүйцэтгэх ажил, үйлчилгээ, нийлүүлэх тоног төхөөрөмжийн жагсаалт

2.1.4. Хэрэв дараагийн шатны төслийг бүртгүүлэх гэж байгаа бол өмнөх төслийн тайланг хавсаргана.

2.2 Төсөл, хөтөлбөрийн ашиглалтын мэдээ гаргах

2.2.1. Төслийн нэгж нь улирлын тайланг тухайн улирлын дараа сарын 15-ны дотор, жилийн тайланг дараа жилийн 1 дүгээр сарын 20-ны дотор **Хүснэгт 2**-оор батлагдсан маягтуудаар гарган хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлнэ.

2.2.2. Хэрэгжүүлэгч байгууллага нь төслийн нэгжүүдийн улирлын тайланг нэгтгэн тухайн улирлын дараа сарын 25-ны дотор, жилийн тайланг нэгтгэн дараа жилийн 2 дугаар сарын 10-ны дотор зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад **Хүснэгт 3**-аар батлагдсан маягтын дагуу хүргүүлнэ.

2.3.3. Зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсөл, хөтөлбөрийн хагас жилийн нэгдсэн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн нэгдсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор гаргаж улсын төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгүүлнэ.

Гурав. Нэгдсэн мэдээллийн санг ашиглах тухай

3.1. Зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нэгдсэн мэдээллийн санг төсөл, хөтөлбөрүүдийн талаар холбогдох тооцоо судалгаа хийх болон бусад албан хэрэгцээнд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд ашиглана.

Дөрөв. Хариуцлага

4.1. Энэ журмыг зөрчсөн байгууллага болон албан тушаалтанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-oOo-

Буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих төслүүдийн ерөнхий танилцуулгын маягт

Шинээр хэлэлцэгдэх төсөлд:

- Ерөнхий хэсэг
 - Төслийн нэр:
 - Санхүүжилтийн төрөл, төслийн төрөл: (Зээл, тусламжийн, техник туслалцаа, судалгааны гэх мэт)
 - Төсөл хэрэгжих хугацаа:
 - Төсөл хаана хэрэгжих:
 - Хариуцах Засгийн газрын байгууллага:
 - Санхүүжүүлэгч байгууллага (Донор, Олон улсын байгууллага)
 - Хамтарсан санхүүжилт (байгаа эсэх, Монголын талын оролцоо)
- Үндсэн хэсэг
 - Төслийн зорилго:
 - Үндэслэл (Төсөл хэрэгжүүлэх шаардлага)
 - Зорилго (Үйл ажиллагаа)
 - Төсөл хэрэгжсэнээр гарах үр дүн
 - Төслийн түүх: (Хэзээ боловсруулсан, судалгаа, нэмэлт засвар, Засгийн газар, УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байдал, ямар шатанд явааг товч тодорхой тусгах)
 - Төслийн эдийн засгийн судалгаа:
 - Санхүүжилт
 - Хөрөнгийн хуваарилалт
 - Зээлийн нөхцөлүүд
 - Зээлийн эргэн төлөлтийн хуваарь
 - Төсөл боловсруулсан байгууллага, багийн гишүүд, холбоо барих утас:

2 дугаар шатны зээлийн гэрээ бол:

- Дээрхи мэдээллээс гадна өмнөх зээлийн гэрээний хэрэгжилтийг дэлгэрэнгүй тусгах

Буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй төслийн улирлын мэдээ Хүснэгт 2

Төслийн тайлант хугацаа	 оны-р улирал				
Төсөл, арга хэмжээний нэр						
Бүртгэлийн дугаар						
Хандивлагч улс, олон улсын байгууллага						
Төслийн хамрах хүрээ						
Төслийн зорилго						
Төслийн зорилгын биелэлт						
Төслийн тайлант хугацааны зорилт						
Төслийн тайлант хугацааны зорилтын биелэлт						
Санхүүжилтийн хэмжээ	Үндсэн валютаар					
	Мян ам доллараар					
Ашиглалтын мэдээ	Тайлант хугацаанд ашигласан	Төсөл эхэлснээс хойш ашигласан:				
		Хөрөнгө оруулалт	Барилга байгууламж			
			Их засвар, өргөтгөл, сэргээн босголтын ажил			
			Машин тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл		
				Бусад машин тоног төхөөрөмж		
			Өсөж үрждэг хөрөнгө			
			Бусад			
		Урсгал зардал	Гадаад, дотоод зөвлөхийн зардал			
			Цалингийн зардал			
			Судалгаа шинжилгээний зардал			
			Ашиглалтын зардал			
			Байрны түрээсийн хөлс			
			Гадаад дотоод томилолтын зардал			
			Эд хогшил худалдан авсан зардал			
			Бусад			
Нийт ашиглалт						
Төслийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээ						

Буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй төслүүдийн улирлын мэдээ

Хүснэгт 3
мян.ам доллар

Яам, агентлаг, төрийн захиргааны байгууллагын нэр.....

Дэс дугаар		1	2	3	4		
Төсөл, арга хэмжээний нэр								
Бүртгэлийн дугаар								
Хандивлагч улс, олон улсын байгууллага								
Төслийн зорилго								
Төслийн зорилгын биелэлт								
Төслийн тайлант хугацааны зорилт								
Төслийн тайлант хугацааны зорилтын биелэлт								
Сайтгүйжилтийн хэмжээ	Үндсэн валютаар					Нийт дүн		
	Мян ам доллараар							
Төсөл эхэлснээс хойш ашигласан:								
Ашиглалтын мэдээ	Тайлант онд ашигласан	Хөрөнгө оруулалт	Барилга байгууламж					
			Их засвар, өргөтгөл, сэргээн босголтын ажил					
			Машин тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл				
				Бусад машин тоног төхөөрөмж				
			Өсөж үрждэг хөрөнгө					
		Урсгал зардал	Бусад					
			Гадаад, дотоод зөвлөхийн зардал					
			Цалингийн зардал					
			Судалгаа шинжилгээний зардал					
			Ашиглалтын зардал					
			Байрны түрээсийн хөлс					
			Гадаад дотоод томилолтын зардал					
			Эд хогшил худалдан авсан зардал					
			Бусад					
		Нийт ашиглалт						
Хэрэгжиж байгаа, батлагдсан, болон нэмэлт мэдээ, тайлбар								